

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС АХМАД НАСТАНД ОЛГОХ ТЭТГЭВЭРТ  
ХАМРАГДАХ ИРГЭНД НАСНЫ ШАЛГУУР**

<b>Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он</b>	<b>Өндөр насны тэтгэвэр тогтоох нас</b>
1957 ба түүнээс өмнө	60 нас
1958	60 нас 3 сар
1959	60 нас 6 сар
1960	60 нас 9 сар
1961	61 нас
1962	61 нас 3 сар
1963	61 нас 6 сар
1964	61 нас 9 сар
1965	62 нас
1966	62 нас 3 сар
1967	62 нас 6 сар
1968	62 нас 9 сар
1969	63 нас
1970	63 нас 3 сар
1971	63 нас 6 сар
1972	63 нас 9 сар
1973	64 нас
1974	64 нас 3 сар
1975	64 нас 6 сар
1976	64 нас 9 сар
1977 ба түүнээс хойш	65 нас

<b>Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он</b>	<b>Өндөр насны тэтгэвэр тогтоох нас</b>
1962 ба түүнээс өмнө	55 нас

1963	55 нас 3 сар
1964	55 нас 6 сар
1965	55 нас 9 сар
1966	56 нас
1967	56 нас 3 сар
1968	56 нас 6 сар
1969	56 нас 9 сар
1970	57 нас
1971	57 нас 3 сар
1972	57 нас 6 сар
1973	57 нас 9 сар
1974	58 нас
1975	58 нас 3 сар
1976	58 нас 6 сар
1977	58 нас 9 сар
1978	59 нас
1979	59 нас 3 сар
1980	59 нас 6 сар
1981	59 нас 9 сар
1982	60 нас
1983	60 нас 3 сар
1984	60 нас 6 сар
1985	60 нас 9 сар
1986	61 нас
1987	61 нас 3 сар
1988	61 нас 6 сар
1989	61 нас 9 сар
1990	62 нас

1991	62 нас 3 сар
1992	62 нас 6 сар
1993	62 нас 9 сар
1994	63 нас
1995	63 нас 3 сар
1996	63 нас 6 сар
1997	63 нас 9 сар
1998	64 нас
1999	64 нас 3 сар
2000	64 нас 6 сар
2001	64 нас 9 сар
2002 ба түүнээс хойш	65 нас

## **Тэтгэвэрт хамрагдахад бүрдүүлэх мартериал**

### **Ахмад настны тэтгэвэр**

- Өргөдөл (маягтын дагуу)
- Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
- Иргэний үнэмлэх
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт.

### **16 насанд хүрсэн одой иргэн**

- Өргөдөл (маягтын дагуу)
- Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
- Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт
- Одой болохыг тогтоосон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр.

### **Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн**

- Өргөдөл (маягтын дагуу)
- Иргэний үнэмлэх
- Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
- нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт
- Хөдөлмөрийн чадвар, алдалтын хувь хэмжээ тогтоосон тухай Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр.

### **Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд**

- Өргөдөл (маягтын дагуу)
- Иргэний үнэмлэх
- Тэжээгчийн нас барсны гэрчилгээ, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх
- 18 хүртэлх насны хүүхдийн төрсний гэрчилгээ, эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн иргэний үнэмлэх
- Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
- 16 нас хүрээд нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгож байгаа иргэнээс бусад иргэнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт
- Сум хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.

Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны 1-2 хүүхдэд Засгийн газраас тогтоосон нийгмийн халамжийн тэтгэврийн, 3-4 хүүхдэд Засгийн газраас тогтоосон нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлсэн, 5 болон түүнээс дээш хүүхдэд Засгийн газраас тогтоосон нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр бодож тэтгэвэр олгоно.

### **Хүсэлт гаргах хэлбэр:**

-ehalamj.mn Халамжийн нэгдсэн системд бүртгүүлж хүсэлт гаргах

-ebarimt.mn цахим төлбөрийн баримтын системд хандаж хүсэлт гаргах

-Харьяа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага, Сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэнд өөрийн биеэр хандаж хүсэлт гаргах

## **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ**

Нийгмийн халамжийн тэтгэмж дараах төрөлтэй байна.

1.асаргааны тэтгэмж

2.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж

3.онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж

4.хүүхдийн мөнгөн тэтгэмж.

### **Асаргааны тэтгэмжийг дараах иргэнд олгоно.**

- бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа;
  - Өргөдөл /маягтын дагуу/
  - Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  - Асруулагчийн иргэний үнэмлэх /16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ/, хуулбарын хамт
  - Эцэг, эхийн нас барсны гэрчилгээ
  - Үрчлэн авсан эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон тухай сум, дүүргийн Засаг даргын захирамж, хуулбарын хамт
  - Сум, хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.
- Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан байгаа;
  - Өргөдөл /маягтын дагуу/
  - Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  - Иргэний үнэмлэх, хуулбарын хамт
  - Асруулагчийн иргэний үнэмлэх /16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ/
  - Эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон, эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан, эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа бол шүүхийн шийдвэр
  - Эцэг, эх нь удаан хугацаагаар (3 сараас дээш) эмнэлэгт эмчлүүлж байгаа бол эмнэлгийн ерөнхий эмчийн тодорхойлолт
  - Эцэг, эх нь хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхэд бол энэ тухай сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  - Хүчирхийллийн улмаас хүүхдэд хамгаалалт шаардлагатай болсон бол энэ тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт
  - Сум, хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.
- тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

- Өргөдөл /маягтын дагуу/
  - Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  - Асруулагчийн иргэний үнэмлэх (16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ)
  - Асрагчийн иргэний үнэмлэх
  - Сум хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.
- эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа.

- Өргөдөл /маягтын дагуу/
- Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
- Иргэний үнэмлэх
- Асруулагчийн иргэний үнэмлэх (16 насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээ)
- Байнгын асаргаа шаардлагатай тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт
- Сум хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.

**Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно.**

- гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх;
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн;
  - Өргөдөл /маягтын дагуу/
  - Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  - Иргэний үнэмлэх
  - Эцэг, эхийн нас барсны гэрчилгээ
  - Сум, хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.
- хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;
  - Өргөдөл /маягтын дагуу/
  - Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  - Иргэний үнэмлэх, хуулбарын хамт

- Харъяа эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газраас орон сууц, үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагаа
  - Ял шийтгэл эдлэж байгаад суллагдсан тухай холбогдох байгууллагын тодорхойлолт
  - Сум, хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр
  - Тухайн өрхийн ӨАТТС-ны онооны тодорхойлолт.
- нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх;
- Өргөдөл /маягтын дагуу/
  - Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  - Өрхийн гишүүдийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ
  - Харъяа эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газраас орон сууц, үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагаа;
  - Сум, хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр;
  - Тухайн өрхийн ӨАТТС-ны онооны тодорхойлолт.
- байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд Засгийн газраас тогтоосон тухайн үеийн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээний тусламжийг.
- Өргөдөл
  - Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  - Хүүхдийн төрсний гэрчилгээ, эсхүл 16 насанд хүрсэн иргэний үнэмлэх
  - Байнгын асаргаа шаардлагатай тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт;
  - Сум, хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.
- байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн;
- Өргөдөл
  - Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  - Иргэний үнэмлэх
  - Байнгын асаргаа шаардлагатай тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт
  - Сум, хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр.
- "Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одон, эсхүл "Эхийн алдар" хоёрдугаар зэргийн одонтой эх мөнгөн тусламж давхардуулахгүйгээр.
- Өргөдөл /маягтын дагуу/
  - Сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
  - Иргэний үнэмлэх,
  - Хүүхдийн төрсний гэрчилгээ эсхүл 16 насанд хүрсэн иргэний үнэмлэх
  - Одонгийн үнэмлэх.

## Хүсэлт гаргах хэлбэр:

-**ehalamj.mn** Халамжийн нэгдсэн системд бүртгүүлж хүсэлт гаргах

-**ebarimt.mn** цахим төлбөрийн баримтын системд хандаж хүсэлт гаргах

-**ТҮЦ машин**” Төрийн үйлчилгээний цахим машинаар дамжуулан хүсэлт гаргах

-**Харьяа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага**

Сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэнд өөрийн биеэр хандаж хүсэлт гаргах